



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/244

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах  
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" А/357 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах, гамшгийн аюулын бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий байнгын ажиллагаатай зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган, зөвлөлийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны "Зөвлөл шинэчлэн байгуулж, ажиллах журам батлах тухай" А/205 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010640

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны  
16 дугаар сарын 12-ны өдрийн 16 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	"Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨТҮГ-ын захирал
	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга
	Дүүргийн Газрын зохион байгуулалтын албаны дарга
	Дүүргийн Цагдаагийн газрын дарга
	Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга
	Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн дарга
	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	"Улаанбаатар цахилгаан сүлжээ" ТӨХК-ийн Чингэлтэй ХҮТ-ийн дарга
	Дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар
	Дүүргийн Нийтлэг үйлчилгээний ОНӨТҮГ-ын дарга

Дүүргийн "Тохижилт үйлчилгээний" ХХК-ийн захирал

"Наши трейд" ХХК-ийн захирал

Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хороо

Нарийн бичгийн  
дарга:

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт,  
нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч

---o0o---